



## МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН ХОЛБООНЫ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

### Журам батлах тухай


Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.1.9 дэх заалт, 48 дугаар зүйлийн 48.9.12 дахь заалт, 48.10 дахь хэсэг, Монголын Хуульчдын холбооны дүрмийн 4.10 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг тус тус үндэслэн Хуульчдын холбооны зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. Монголын Хуульчдын холбооны “Хууль тогтоох үйл ажиллагаанд мэргэжлийн шинжээчийн туслалцаа үзүүлэх журам”-ыг хавсралтаар баталсугай.
2. Энэ тогтоолыг 2023 оны 03 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ХУРАЛ ДАРГАЛАГЧ



Л.ОДГЭРЭЛ



**ХУУЛЬ ТОГТООХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД  
МЭРГЭЖЛИЙН ШИНЖЭЭЧИЙН ТУСЛАЛЦАА  
ҮЗҮҮЛЭХ ЖУРАМ**

**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ  
НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

**1.1 дүгээр зүйл. Журмын зорилго**

1. Энэ журмын зорилт нь Монголын Хуульчдын холбоо /цаашид "Холбоо" гэх/, түүний бүтцийн байгууллагуудаас хууль тогтоох үйл ажиллагаанд мэргэжлийн шинжээчийн туслалцаа үзүүлэх чиг үүргийг хэрэгжүүлэх болон гишүүн хуульчдаас хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актын төсөлд санал өгөх, нөлөөллийн үйл ажиллагаа явуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

**1.2 дугаар зүйл. Журмын нэр томъёоны тодорхойлолт**

1. Энэ журамд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

1.1. "Мэргэжлийн шинжээчийн туслалцаа үзүүлэх" гэж хууль тогтоох байгууллага болон хууль санаачлагч, төрийн байгууллагаас Холбоонд хандаж, эсхүл Холбооны санаачилгаар хууль зүйн мэргэшлийн тусгай мэдлэг шаардсан асуудлаар дүгнэлт гаргах, санал өгөх, судалгаа хийх үйл ажиллагааг;

1.2. "Албан ёсны санал боловсруулах үйл ажиллагаа" гэж хууль тогтоох байгууллага болон хууль санаачлагч, төрийн байгууллагаас Холбоонд хандаж, эсхүл Холбооны санаачилгаар ирүүлсэн хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актын төсөлд санал өгөх, боловсронгуй болгоход чиглэсэн зохион байгуулалтын цогц арга хэмжээг;

1.3. "Сайн дурын санал боловсруулах үйл ажиллагаа" гэж хууль санаачлагч болон холбогдох эрх бүхий этгээдтэй байгуулсан гэрээний үндсэн дээр хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актын төсөл боловсруулахад хамтран ажиллаж буй Холбооны гишүүн хуульчийн үйл ажиллагаа болон хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актын төсөл санаачлагчаас иргэд, олон нийтэд хандан байршуулсан төсөлд хуульчдаас чиг үүргийн болон сайн дурын хороогоор дамжуулан гаргасан саналыг хүлээн авч, шийдвэрлэх арга хэмжээг;

1.4. "Зөвлөхүүдийн зөвлөл" гэж Холбооны Ерөнхийлөгчийн дэргэд бодлогын нөлөөллийн ажлыг зохион байгуулах, зөвлөн туслах чиг үүрэг бүхий хууль тогтоомжид заасан хуульчдын төлөөллийг.

**1.3 дугаар зүйл. Журмын үйлчлэх хүрээ**

1. Энэ журам нь хууль тогтоомжийн төсөл санаачлагч, хууль тогтоох үйл ажиллагаанд мэргэжлийн шинжээчийн туслалцаа үзүүлэхэд холбогдох чиг үүргийн болон сайн дурын хороогоор дамжуулан хуульчдаас санал авах, Зөвлөхүүдийн зөвлөлийн ажиллах үндэс, бодлогын нөлөөллийн ажлыг үр дүнтэй, хэрэгжихүйц, бодитой, оновчтой зохион байгуулахад чиглэнэ.

2. Энэхүү журмаар зохицуулагдаагүй харилцааг Холбооны Ерөнхийлөгч бүрэн эрхийнхээ хүрээнд тухай бүр шийдвэрлэх эрхтэй.

**1.4 дүгээр зүйл. Нийтлэг зарчим**

1. Энэ журмыг хэрэгжүүлэхэд дараах нийтлэг зарчмыг баримтална:

1.1. хууль дээдлэх;

- 1.2.ил тод, нээлттэй байх;
- 1.3.хуульчдын оролцоог хангах;
- 1.4.ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх;
- 1.5.судалгаа, шинжилгээнд үндэслэсэн байх.

**ХОЁРДУГААР БҮЛЭГ  
МЭРГЭЖЛИЙН ШИНЖЭЭЧИЙН ТУСЛАЛЦААНЫ  
ТӨРӨЛ, ХЭЛБЭР**

**2.1 дүгээр зүйл.Мэргэжлийн шинжээчийн туслалцаа үзүүлэх төрөл**

1.Хууль тогтоох, захиргааны хэм хэмжээний акт батлах үйл ажиллагаанд Хуульчдын холбоо нь мэргэжлийн шинжээчийн туслалцааг дараах төрлөөр явуулна:

- 1.1.анхдагч хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актын төсөлд шинжээчийн туслалцаа;
- 1.2.хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актад өөрчлөлт оруулах төсөлд шинжээчийн туслалцаа;
- 1.3.хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актын шинэчилсэн найруулгын төсөлд шинжээчийн туслалцаа;
- 1.4.хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актын багц төсөлд шинжээчийн туслалцаа;
- 1.5.хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний акт хүчингүй болсонд тооцох тухай төсөлд шинжээчийн туслалцаа;
- 1.6.хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актын хэрэгжилтийн үр дагавар, үнэлгээ.
- 1.7.бусад дүн шинжилгээ

**2.2 дугаар зүйл.Мэргэжлийн шинжээчийн туслалцаа үзүүлэх хэлбэр**

1.Хууль тогтоох, захиргааны хэм хэмжээний акт батлах үйл ажиллагаанд Хуульчдын холбоо нь мэргэжлийн шинжээчийн туслалцааг дараах хэлбэрээр явуулна:

- 1.1.хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актын төслийн дүн шинжилгээ;
- 1.2.хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актын төслийн санал, зөвлөмж, дүгнэлт;
- 1.3.хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актын төслийн эрх зүйн шүүмж;
- 1.4.хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актын төслийн эрх зүйн судалгаа;
- 1.5.хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актын төсөл боловсруулах аргачлалын дагуу гүйцэтгэсэн төсөл;
- 1.6.хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актын төсөлд шаардлагатай дагалдах судалгааны ажлууд;
- 1.7.шаардлагатай бусад.

**ГУРАВДУГААР БҮЛЭГ  
ХОЛБООНЫ ЕРӨНХИЙЛӨГЧ, ТАМГЫН ГАЗАР,  
ЗӨВЛӨХҮҮДИЙН ЗӨВЛӨЛИЙН  
БҮРЭН ЭРХ, ЧИГ ҮҮРЭГ**

**3.1 дүгээр зүйл.Холбооны Ерөнхийлөгч /цаашид “Ерөнхийлөгч” гэх/-ийн бүрэн эрх, хэрэгжүүлэх чиг үүрэг**

1.Ерөнхийлөгч нь хууль тогтоох үйл ажиллагаанд мэргэжлийн шинжээчийн туслалцаа үзүүлэх үйл ажиллагаанд дараах бүрэн эрхийг эдэлнэ:

1.1.мэргэжлийн шинжээчийн туслалцаа үзүүлэх үйл ажиллагаа болон бодлогын нөлөөллийн ажлыг нэгдсэн удирдлагаар хангах;

1.2.хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актын төслийг боловсронгуй болгох чиглэлээр холбогдох хороонд чиглэл, зөвлөмж өгөх;

1.3.албан ёсны санал боловсруулах үйл ажиллагааг нэгтгэн зохион байгуулах;

1.4.хууль зүйн бодлогын асуудалтай холбоотойгоор хуульчдын байр суурийг Улсын Их Хурал, Засгийн газар, Үндсэн хуулийн цэцийн өмнө Хуульчдын холбоог төлөөлөн албан ёсны байр суурь илэрхийлэх;

1.5.мэргэжлийн шинжээчийн туслалцаа үзүүлэх үйл ажиллагаа болон бодлогын нөлөөллийн ажлын явц, биелэлтэд хяналт тавих;

1.6.мэргэжлийн шинжээчийн туслалцаа үзүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг тухайн жилийн батлагдсан төсөвтөө багтаан хэрэгжүүлэх;

1.7.хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актын төсөлд хуульчдаас ирүүлсэн санал, байр суурийг гадаад, дотоод харилцаанд илэрхийлэх;

1.8.шаардлагатай тохиолдолд дэмжлэг үзүүлэх судалгаа, шинжилгээний бүтцийг байгуулах;

1.9.сайн дурын санал боловсруулах үйл ажиллагаанаас гаргасан санал, зөвлөмжийг холбогдох эрх бүхий этгээдэд уламжлах эсэх асуудлыг шийдвэрлэх;

1.10.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

2.Ерөнхийлөгч нь хууль тогтоох үйл ажиллагаанд мэргэжлийн шинжээчийн туслалцаа үзүүлэх үйл ажиллагаанд дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

2.1.хууль тогтоох үйл ажиллагаанд мэргэжлийн шинжээчийн туслалцаа үзүүлэх ажиллагааг нэгтгэн зохион байгуулах;

2.2.чиг үүргийн болон сайн дурын хороодоос ирүүлсэн хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актын төслийг боловсронгуй болгох санал, зөвлөмжид шаардлагатай судалгаа, шинжилгээг Тамгын газраар гүйцэтгүүлэх;

2.3.бодлогын асуудлаар хуульчдын дунд хэлэлцүүлэг зохион байгуулж, гаргасан санал, зөвлөмжийг гадаад, дотоод харилцаанд илэрхийлэх;

2.4.хууль тогтоомжид заасан бусад.

### 3.2 дугаар зүйл.Тамгын газрын чиг үүрэг

1.Тамгын газар нь хууль тогтоох үйл ажиллагаанд мэргэжлийн шинжээчийн туслалцаа үзүүлэхэд дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

1.1.Ерөнхийлөгчөөс өгсөн үүрэг, даалгаврыг шуурхай гүйцэтгэж, биелэлтийг Ерөнхийлөгчийн өмнө хариуцах

1.2.хууль тогтоох үйл ажиллагаанд мэргэжлийн шинжээчийн туслалцаа үзүүлэхэд шаардлагатай мэдээлэл, судалгаагаар тухай бүр хангаж, зохион байгуулалтын арга хэмжээ авч, дэмжлэг үзүүлэх ажлыг Судалгааны төвөөр дамжуулан хэрэгжүүлэх;

1.3.бодлогын нөлөөллийн ажлыг зохион байгуулах, хэрэгжүүлэх;

1.4.Зөвлөхүүдийн зөвлөл болон Дэд хороодод шаардлагатай дэмжлэг, туслалцаа үзүүлэх.

### 3.3 дүгээр зүйл.Зөвлөлийн эрх зүйн үндэс

1.Зөвлөхүүдийн зөвлөл /цаашид "Зөвлөл" гэх/-ийн бүрэлдэхүүн одоо эрхэлж байгаа ажил нь давхар ажил эрхлэлтээр хязгаарлагдаагүй бол Хуульчдын холбооны Ерөнхийлөгч, Үндсэн хуулийн цэцийн дарга, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын ерөнхий

прокурор, Улсын Их Хурал, Засгийн газрын гишүүнээр ажиллаж байсан хуульчдын санал, хүсэлтийг харгалзан бүрдүүлнэ.

2.Зөвлөл нь Холбооны Ерөнхийлөгчийн дэргэд ажиллана.

3.Зөвлөлийн бүрэлдэхүүнд энэ зүйлийн 1 дэх хэсэгт зааснаас гадна шаардлагатай тохиолдолд мэргэшсэн хуульчдыг оролцуулах эсэх асуудлыг Хуульчдын Холбооны зөвлөл шийдвэрлэнэ.

### **3.2 дугаар зүйл.Зөвлөлийн хуралдаан**

1.Зөвлөлийн зохион байгуулалтын үйл ажиллагааны хэлбэр нь хуралдаан байна. Зөвлөлийн хуралдааныг нийт гишүүдийн олонх оролцсоноор хүчинтэйд тооцож, хуралдаанд оролцсон гишүүдийг олонхын саналаар асуудлыг шийдвэрлэнэ.

2.Зөвлөлийн хуралдаанаас дараах шийдвэрүүдийн аль нэгийг гаргана:

2.1.Хууль зүйн бодлогын нөлөөллийн ажлыг зохион байгуулах арга хэмжээний төлөвлөгөөг баталж, хэрэгжилтэд хяналт тавих;

2.2.Бодлогын нөлөөллийн ажлыг эрчимжүүлэх, удаашралтай асуудлыг шийдвэрлэх талаар арга зүйн зөвлөмж гаргах;

2.3.Холбооны Ерөнхийлөгчийг мэдээллээр хангах.

## **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ АЛБАН ЁСНЫ САНАЛ БОЛОВСРУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА**

### **4.1 дүгээр зүйл.Хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актын төслийг хуваарилах, хуульчдад хүргэх**

1.Холбооноос албан ёсоор санал авахаар ирүүлсэн хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актын төслийг Ерөнхийлөгч холбогдох чиг үүргийн болон сайн дурын хороонд Тамгын газраар дамжуулан ажлын 2 хоногийн дотор хүргүүлнэ.

2.Хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актын төсөлд санал, дүгнэлт боловсруулахаар хүргүүлсэн чиг үүргийн болон сайн дурын хороод нь Ерөнхийлөгчөөс тогтоосон хугацаанд хариу бэлтгэх үндсэн үүрэгтэй байна.

3.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актын төслийн төрөл, хэлбэр, зохицуулах харилцаанаас нь хамааруулан хэд хэдэн чиг үүргийн болон сайн дурын хороонд зэрэг хуваарилж болно.

4.Хэд хэдэн хороодод хуваарилсан тохиолдолд тухайн хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актын төслөөр зохицуулж буй голлох харилцаанд хамаарах хороо нь санал, дүгнэлтийг нэгтгэн, Ерөнхийлөгчийн өмнө хариуцна.

5.Тамгын газар хуульчдаас санал авах мэдээллийг холбогдох хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актын төслийн хамт хүлээн авсан өдрөөс хойш 1 өдрийн дотор багтааж Холбооны цахим хуудаст байршуулж, нийт хуульчдад хүргэнэ.

6.Энэ зүйлийн 5 дахь хэсэгт заасан мэдээллийг цахим хуудаст оруулахад хуульчдын бичгээр санал ирүүлэх хугацааг хариуцсан чиг үүргийн болон сайн дурын хороодтой харилцан зөвшилцөж тогтооно.

### **4.2 дугаар зүйл.Хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актын төсөлд санал өгөхөд чиг үүргийн хороодын зохион байгуулалт**

1.Хууль зүйн шинжлэх ухаан, боловсролын хөгжлийг дэмжих хороо нь хууль тогтоох үйл ажиллагаанд мэргэжлийн шинжээчийн туслалцаа үзүүлэхэд бусад чиг үүргийн хороодыг нэгдсэн удирдлага, арга зүйгээр хангаж ажиллана.

2.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хороо нь хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актын төсөлд санал өгөх хуульчдын оролцоо, төслийг боловсронгуй болгох

асуудлаар зохион байгуулалтын арга хэмжээ авч, хэрэгжилтийг Холбооны Ерөнхийлөгчийн өмнө хариуцна.

3.Хууль зүйн шинжлэх ухаан, боловсролын хөгжлийг дэмжих хороо нь сайн дурын хороодтой хамтран ажиллаж, хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актын төсөлд нэгдсэн нэг санал, дүгнэлтийг гаргана.

4.Энэ журмын 4.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар Ерөнхийлөгч хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актын төслийг хэд хэдэн хороодод хуваарилсан бол Хууль зүйн шинжлэх ухаан, боловсролын хөгжлийг дэмжих хороо арга зүйн удирдамжаар хангана.

5.Чиг үүргийн хорооны дэргэд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актын төсөлд санал өгөх, мэргэжлийн шинжээчийн туслалцаа үзүүлэхэд чиглэсэн дэд хороо байгуулж болно.

#### **4.3 дугаар зүйл.Хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актын төсөлд санал өгөхөд сайн дурын хороодын зохион байгуулалт**

1.Хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актын төсөлд санал өгөх, мэргэжлийн шинжээчийн туслалцаа үзүүлэхэд тухайн салбар эрх зүйн хорооны дэргэд дэд хороо байгуулж болно.

2.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан сайн дурын хороо, түүний дэд хороо нь хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актын төсөлд санал өгөх хуульчдын оролцоо, хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актын төслийг боловсронгуй болгох асуудлаар зохион байгуулалтын арга хэмжээ авч, хэрэгжилтийг Холбооны Ерөнхийлөгчийн өмнө хариуцна.

3.Сайн дурын хороод нь шаардлагатай гэж үзвэл хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актын төслийг боловсронгуй болгох, хууль тогтоох үйл ажиллагаанд мэргэжлийн шинжээчийн туслалцаа үзүүлэхэд шаардлагатай санхүүжилт, техник хэрэгслийн хангах зэрэг асуудлыг Холбооны Ерөнхийлөгчид танилцуулж, шийдвэрлүүлнэ.

4.Холбооны Ерөнхийлөгч, Тамгын газар нь энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасан үйл ажиллагааг боломжит хэмжээнд дэмжлэг үзүүлнэ.

5.Хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актын төслийг тухайн салбар эрх зүйн хороогоор заавал хэлэлцүүлж, санал дүгнэлт гаргасан байна.

#### **4.4 дүгээр зүйл.Хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актын төсөлд ирүүлсэн саналыг нэгтгэх, биелэлтийг Ерөнхийлөгчид танилцуулах**

1.Чиг үүргийн болон сайн дурын хороод нь хуульчдаас ирүүлсэн хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актын төсөлд хүргүүлэх саналыг Хууль тогтоомжийн тухай хууль, Захиргааны Ерөнхий хууль болон холбогдох журам, аргачлалын хүрээнд боловсруулна.

2.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан санал нь давхардал, хийдэлгүй байх бөгөөд хууль зүйн техник, найруулга зүйн хувьд хоёрдмол утгагүй, ойлголтын зөрүү үүсгэхгүй байхаар боловсруулсан байна.

3.Энэ зүйлийн 1, 2 дахь хэсэгт зааснаар хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актын төсөлд ирүүлсэн бүхий л саналыг жагсаалт хэлбэрээр товьёг гаргасан байна.

4.Энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасан товьёг нь санал ирүүлсэн хуульч, өгсөн санал, саналыг тусгасан эсэх, тусгаагүй бол ямар үндэслэл, шалтгаанаар тусгаагүй талаарх мэдээллийг агуулсан байна.

5.Хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актын төслийн талаарх эцэслэсэн саналаа холбогдох баримт, тооцоо, судалгааны хамт Холбооны Ерөнхийлөгчид шууд хүргүүлнэ.

6.Чиг үүргийн болон сайн дурын хороодоос ирүүлсэн хууль тогтоомжийн төслийн эцэслэсэн саналыг Холбооны Ерөнхийлөгч, Тамгын газар агуулгын шинжтэй нэмэлт, хасалт, өөрчлөлт оруулахыг хориглоно.

7.Холбооны Ерөнхийлөгч нь холбогдох судалгаа дутуу, бүрдлийн шаардлага хангаагүй хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актын төслийн саналыг засварлуулахаар хугацаа тогтоож зохих чиг үүргийн болон сайн дурын хороонд шилжүүлж болно.

### **ТАВДУГААР БҮЛЭГ МЭРГЭЖЛИЙН ШИНЖЭЭЧИЙН ТУСЛАЛЦАА ҮЗҮҮЛЭХ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ**

#### **5.1 дүгээр зүйл.Мэргэжлийн шинжээчийн туслалцаа үзүүлэх ажлыг зохион байгуулах**

1.Холбооноос албан ёсоор санал авахаар ирүүлсэн хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актын төсөлд мэргэжлийн шинжээчийн туслалцаа үзүүлэхэд Ерөнхийлөгч холбогдох чиг үүргийн болон сайн дурын хороонд Тамгын газраар дамжуулан ажлын 2 хоногийн дотор хүргүүлнэ.

2.Хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актын төсөлд санал, дүгнэлт боловсруулахаар хүргүүлсэн чиг үүргийн болон сайн дурын хороод нь Ерөнхийлөгчөөс тогтоосон хугацаанд хариу бэлтгэх үндсэн үүрэгтэй байна.

3.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үйл ажиллагааг зохион байгуулахад сайн дурын болон чиг үүргийн хороод нь тухайн салбар эрх зүйгээр мэргэшсэн хуульчдыг оролцуулна.

4.Мэргэшсэн хуульчдын ажлын төлөвлөгөө, хуваарилалтыг тухайн хариуцсан хороод хэрэгжүүлж, биелэлтийг Холбооны Ерөнхийлөгчийн өмнө хариуцна.

5.Тамгын газар хуульчдаас санал авах мэдээллийг холбогдох хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актын төслийн хамт хүлээн авсан өдрөөс хойш 1 өдрийн дотор багтааж Холбооны цахим хуудаст байршуулж, нийт хуульчдад хүргэнэ.

6.Энэ зүйлийн 5 дахь хэсэгт заасан мэдээллийг цахим хуудаст оруулахад хуульчдын бичгээр санал ирүүлэх хугацааг хариуцсан чиг үүргийн болон сайн дурын хороодтой харилцан зөвшилцөж тогтоосон байна.

7.Хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актын төсөлд гаргасан мэргэшсэн хуульчдын санал, дүгнэлтийг нийт хуульчдад хүргэх ажлыг хариуцсан хороо хэрэгжүүлнэ.

8.Хороо нь мэргэжлийн шинжээчийн туслалцаа үзүүлэхдээ хуульчдын дунд хэлэлцүүлэг зохион байгуулсан байна.

9.Энэ зүйлийн 8 дахь хэсэгт заасан хэлэлцүүлгийг танхимын болон танхимын бус хэлбэрээр зохион байгуулж болно.

10.Хууль зүйн дүн шинжилгээг мэргэшсэн хуульчаар эсхүл хууль зүйн ухааны магистр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй хуульчаар гүйцэтгүүлсэн байна.

11.Хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актын төслийн эрх зүйн шүүмжийг тухайн салбар эрх зүйн хороонд хамаарах хуульчаар гүйцэтгүүлнэ.

12.Хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актын төслийн эрх зүйн судалгаа, шинжилгээг хуульч-эрдэмтнээр ахлуулсан ажлын хэсэг байгуулж гүйцэтгүүлнэ. Ажлын хэсгийг тухайн салбар эрх зүйн хорооны саналыг үндэслэн Холбооны Ерөнхийлөгч байгуулна.

### **ЗУРГААДУГААР БҮЛЭГ САЙН ДУРЫН САНАЛ БОЛОВСРУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА**

6.1 дүгээр зүйл.Хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актын төсөлд хуульчдаас ирүүлсэн саналыг хуваарилах

7.Холбооны Ерөнхийлөгч нь холбогдох судалгаа дутуу, бүрдлийн шаардлага хангаагүй хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актын төслийн саналыг засварлуулахаар хугацаа тогтоож зохих чиг үүргийн болон сайн дурын хороонд шилжүүлж болно.

## **ТАВДУГААР БҮЛЭГ МЭРГЭЖЛИЙН ШИНЖЭЭЧИЙН ТУСЛАЛЦАА ҮЗҮҮЛЭХ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ**

### **5.1 дүгээр зүйл.Мэргэжлийн шинжээчийн туслалцаа үзүүлэх ажлыг зохион байгуулах**

1.Холбооноос албан ёсоор санал авахаар ирүүлсэн хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актын төсөлд мэргэжлийн шинжээчийн туслалцаа үзүүлэхэд Ерөнхийлөгч холбогдох чиг үүргийн болон сайн дурын хороонд Тамгын газраар дамжуулан ажлын 2 хоногийн дотор хүргүүлнэ.

2.Хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актын төсөлд санал, дүгнэлт боловсруулахаар хүргүүлсэн чиг үүргийн болон сайн дурын хороод нь Ерөнхийлөгчөөс тогтоосон хугацаанд хариу бэлтгэх үндсэн үүрэгтэй байна.

3.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үйл ажиллагааг зохион байгуулахад сайн дурын болон чиг үүргийн хороод нь тухайн салбар эрх зүйгээр мэргэшсэн хуульчдыг оролцуулна.

4.Мэргэшсэн хуульчдын ажлын төлөвлөгөө, хуваарилалтыг тухайн хариуцсан хороод хэрэгжүүлж, биелэлтийг Холбооны Ерөнхийлөгчийн өмнө хариуцна.

5.Тамгын газар хуульчдаас санал авах мэдээллийг холбогдох хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актын төслийн хамт хүлээн авсан өдрөөс хойш 1 өдрийн дотор багтааж Холбооны цахим хуудаст байршуулж, нийт хуульчдад хүргэнэ.

6.Энэ зүйлийн 5 дахь хэсэгт заасан мэдээллийг цахим хуудаст оруулахад хуульчдын бичгээр санал ирүүлэх хугацааг хариуцсан чиг үүргийн болон сайн дурын хороодтой харилцан зөвшилцөж тогтоосон байна.

7.Хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актын төсөлд гаргасан мэргэшсэн хуульчдын санал, дүгнэлтийг нийт хуульчдад хүргэх ажлыг хариуцсан хороо хэрэгжүүлнэ.

8.Хороо нь мэргэжлийн шинжээчийн туслалцаа үзүүлэхдээ хуульчдын дунд хэлэлцүүлэг зохион байгуулсан байна.

9.Энэ зүйлийн 8 дахь хэсэгт заасан хэлэлцүүлгийг танхимын болон танхимын бус хэлбэрээр зохион байгуулж болно.

10.Хууль зүйн дүн шинжилгээг мэргэшсэн хуульчаар эсхүл хууль зүйн ухааны магистр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй хуульчаар гүйцэтгүүлсэн байна.

11.Хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актын төслийн эрх зүйн шүүмжийг тухайн салбар эрх зүйн хороонд хамаарах хуульчаар гүйцэтгүүлнэ.

12.Хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актын төслийн эрх зүйн судалгаа, шинжилгээг хуульч-эрдэмтнээр ахлуулсан ажлын хэсэг байгуулж гүйцэтгүүлнэ. Ажлын хэсгийг тухайн салбар эрх зүйн хорооны саналыг үндэслэн Холбооны Ерөнхийлөгч байгуулна.

## **ЗУРГААДУГААР БҮЛЭГ САЙН ДУРЫН САНАЛ БОЛОВСРУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА**

6.1 дүгээр зүйл.Хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актын төсөлд хуульчдаас ирүүлсэн саналыг хуваарилах



1.Хууль тогтоох болон холбогдох эрх бүхий этгээд өөрийн албан ёсны цахим хуудаст байршуулсан хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актын төсөлд хуульчдаас санал ирүүлж болно.

2.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан санал нь Хууль тогтоомжийн тухай хууль, Захиргааны Ерөнхий хууль болон холбогдох журам, аргачлалд нийцсэн байна.

3.Хуульчаас Холбоонд хаяглаж ирүүлсэн хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актын төслийг Ерөнхийлөгч чиг үүргийн болон сайн дурын хороонд Тамгын газраар дамжуулан ажлын 2 хоногийн дотор хүргүүлнэ.

4.Хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актын төсөлд санал, дүгнэлт боловсруулахаар хүргүүлсэн чиг үүргийн болон сайн дурын хороод нь Ерөнхийлөгчөөс тогтоосон хугацаанд хариу бэлтгэх үндсэн үүрэгтэй байна.

**6.2 дугаар зүйл. Хуульчаас гаргасан хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актын төслийн сайн дурын саналыг шийдвэрлэх**

1.Энэ журмын 6.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актын төсөлд ирүүлсэн саналыг холбогдох чиг үүргийн болон сайн дурын хороодын хурлаар хэлэлцэнэ.

2.Хорооны хурлаар хэлэлцэж дараах шийдвэрийн аль нэгийг гаргана:

2.1.хуульчийн ирүүлсэн саналыг бүхэлд нь дэмжиж, хууль санаачлагчид Холбооны нэрийн өмнөөс хүргүүлэх нь зүйтэй гэж үзэн Ерөнхийлөгчид уламжлах;

2.2.саналыг дахин сайжруулан судлах шаардлагатай гэж үзвэл энэ талаар Ерөнхийлөгчид танилцуулж, санал гаргасан хуульчид мэдэгдэх;

2.3.хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актын төслийн цар хүрээнээс хамааруулан энэ журамд заасны дагуу хуульчаас гаргасан саналыг боловсронгуй болгох чиглэлээр зөвлөмж бэлтгэн Ерөнхийлөгчид хүргүүлэх;

2.4.хуульчийн ирүүлсэн санал нь Хууль тогтоомжийн тухай хууль, Захиргааны Ерөнхий хууль болон холбогдох журам, аргачлалын дагуу боловсруулаагүй байвал энэ талаар санал гаргасан хуульчид бичгээр хариу мэдэгдэх.

3.Энэ зүйлийн 2.1, 2.2, 2.3-д заасан шийдвэрийг холбогдох хорооноос гаргасан бол Холбооны Ерөнхийлөгч өөрийн бүрэн эрхийн хүрээнд энэхүү журмын дагуу шийдвэрлэж, зохион байгуулалтын арга хэмжээ авахыг Тамгын газарт хариуцуулна.

4.Хорооноос энэ зүйлийн 2.4-т заасан шийдвэрийг гаргасан нь хуульч дахин тухайн хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актын төслийн санал гаргах эрхийг хязгаарлах үндэслэл болохгүй.

## **ДОЛООДУГААР БҮЛЭГ НӨЛӨӨЛЛИЙН АЖЛЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**

**7.1 дүгээр зүйл.Нөлөөллийн ажлын нэгдсэн удирдлага**

1.Хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актын төсөл, хууль зүйн бодлогын асуудлаар нөлөөллийн ажил гүйцэтгэх хэрэгцээ, шаардлагыг Холбооны Ерөнхийлөгч тухай бүр шийдвэрлэнэ.

2.Нөлөөллийн ажлыг нийгэм, соёл, улс төр, эдийн засаг, байгаль орчин зэрэг чиглэлээр Тамгын газар, чиг үүргийн болон сайн дурын хороод хариуцан хэрэгжүүлнэ.

3.Нөлөөллийн ажил нь дараах хэлбэртэй байна:

3.1.хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актыг иргэд, олон нийтэд сурталчлах;

3.2.хууль тогтоох үйл ажиллагаанд мэргэжлийн шинжээчийн туслалцаа үзүүлсэн талаарх мэдээлэл;

3.3.хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актын төслийн талаар Холбооны албан ёсны байр суурь, санал, дүгнэлт, зөвлөмжийг нийтэд ил тод, хүртээмжтэй хүргэх;

3.4.хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актын төслийн талаарх мэдээллийг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжуулан хүргэх;

3.5.иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үүднээс сурталчилгаа, гарын авлага, танилцуулга бэлтгэх;

3.6.хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актын төслийг боловсруулах, мэргэжлийн шинжээчийн туслалцаа үзүүлэхэд Улсын Их Хурал, холбогдох байнгын хороо, Ерөнхийлөгчийн Тамгын газар, Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага, Засгийн газар, Яам, Бүх шатны Засаг дарга, Агентлагтай хамтран ажиллах;

3.7.холбооны Ерөнхийлөгчийн хууль зүйн бодлогын нөлөөллийн бусад үйл ажиллагаа.

## **7.2 дугаар зүйл. Тамгын газрын нөлөөллийн ажил дахь оролцоо**

1. Тамгын газар нь хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний акттай холбогдох нөлөөллийн ажлыг Ерөнхийлөгчийн үүрэг, даалгаврын дагуу шуурхай зохион байгуулна.

2.Нөлөөллийн ажлыг Тамгын газар эрхлэн гүйцэтгэхдээ зохион байгуулалтын арга хэмжээ авах, мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх орон тооны 2-оос доошгүй ажилтантай байна.

3.Тухайн жилийн төлөвлөгөө, тайланд нөлөөллийн ажлын арга хэмжээг төлөвлөн гүйцэтгэх бөгөөд жилийн эцсийн тайланг Холбооны Ерөнхийлөгчид танилцуулна.

4.Чиг үүргийн болон сайн дурын хороодтой нягт хамтран ажиллаж, нөлөөллийн ажлыг үр дүнтэй зохион байгуулах төлөвлөгөө боловсруулж, Ерөнхийлөгчөөр батлуулсан байна.

5.Нөлөөллийн ажлын явцад үүссэн асуудлыг тухай бүр Ерөнхийлөгчид танилцуулан холбогдох заавар, зөвлөмжийн дагуу үйл ажиллагааг тасралтгүй, хэвийн явуулна.

6.Тамгын газрын нөлөөллийн ажлын зохион байгуулалтад Зөвлөхүүдийн Зөвлөл хяналт тавих бөгөөд үр дүнг тухай бүр Ерөнхийлөгчид танилцуулна.

## **7.3 дугаар зүйл.Нөлөөллийн ажил дахь хуульчдын оролцоо**

1.Хуульчид нь хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актын төсөл, хууль зүйн бодлогын чиглэлээр нөлөөллийн ажилд оролцохдоо өөрсдийн чиг үүргийн болон сайн дурын хороодоор дамжуулан оролцоно.

2.Чиг үүргийн болон сайн дурын хороод нь хуульчдыг нөлөөллийн ажилд идэвхтэй оролцуулж, Тамгын газрын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ.

3.Хуульчид нь аливаа нөлөөллийн ажилд өөрсдийн сайн дурын үндсэн дээр оролцох бөгөөд хэдийд ч тухайн нөлөөллийн ажлаас татгалзах эрхтэй байна.

4.Хуульчид сайн дурын үндсэн дээр нөлөөллийн ажилд оролцсонд Холбоо, Ерөнхийлөгч, Тамгын газар хариуцлага хүлээхгүй.

5.Хуульчид нөлөөллийн ажлын зорилго, чиглэлд нийцээгүй, ашиг сонирхлын зөрчилтэй үйл ажиллагаа явуулсан тохиолдолд Холбооны Ерөнхийлөгч энэ тухай өөрт нь мэдэгдэж, шаардлагатай тохиолдолд албан ёсоор нийтэд мэдээлж болно.

6.Энэ зүйлийн 5 дахь хэсэгт заасан ашиг сонирхлын зөрчилд нөлөөллийн ажлыг хэрэгжүүлэхэд харшаар нөлөөлж болохуйц нөхцөл байдлыг ойлгоно.

## **НАЙМДУГААР БҮЛЭГ БУСАД**

### **8.1 дүгээр зүйл.Журмын хэрэгжилтийн хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ**

1.Энэхүү журмын хэрэгжилтийг хангасан Тамгын газрын ажилтан, албан хаагчдад цалин-хөлс, шагнал, урамшуулал олгох эсэх асуудлыг Тамгын газрын даргын саналыг үндэслэн Ерөнхийлөгч шийдвэрлэнэ.

2.Хуульчид хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актын төслийн санал боловсруулах, хууль тогтоох үйл ажиллагаанд мэргэжлийн шинжээчийн туслалцаа үзүүлсэн бол хуульчийн үргэлжилсэн сургалтын багц цагийн тодорхой хувийг хангасанд тооцно.

3.Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан багц цаг тооцох асуудлыг Хуульчийн үргэлжилсэн сургалт зохион байгуулах, багц цаг тооцох журмын дагуу шийдвэрлэнэ.

4.Хуульчийн идэвх, оролцоог харгалзан шагнал, урамшуулал олгох асуудлыг Тамгын газрын даргын санал болгосноор Ерөнхийлөгч тухай бүр шийдвэрлэнэ.

## **8.2 дугаар зүйл.Журам хүчин төгөлдөр болох**

1.Энэ журмыг 2023 оны .... сарын ....-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

---oo0oo---

~~XXXXXXXXXXXXXXXXXXXX~~